

ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**«АЛС ДОРНОДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ»* ГЭДЭГ
СЭТГҮҮЛД БНМАУ-ЫН ТАЛААР НИЙТЛЭГДСЭН ЗАРИМ
ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙД****Ш. Бира, академич**

БНМАУ-аас социалист байгуулалтандаа олж байгаа их ололт амжилтыг дэлхийн олон нийт хүлээн зөвшөөрч ихээхэн сонирхон судлах болж байгааг зөвхөн социализм, ардчилал, дэвшлийн замаар хөгжиж байгаа улсуудын төдийгүй, мөн хөрөнгөтөн ертөнцийн орнуудын зарим тогтмол хэвлэлүүдийн хэрэглэгдэхүүн, мэдээ баримт ч тодорхой гэрчилж байна.

Үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөө бодит социализмын замаар амжилттай хөгжиж байгаа манай улсын үзтэл илэрхий амжилтыг хөрөнгөтний судлаачид, сэтгүүлчид урьдын адил бүхэлд нь ор тас үгүйсгэх буюу, хүчээр мушгин гуйвуулж чадахгүй болж одоогийн уншигч олны эрэлт шаардлагад хачигдан БНМАУ-ын тухай зарим үед бодит байдлаар бичих буюу ихэнх тохиолдолд тийм байдлаар бичих гэсэн ойлголт, сэтгэгдэл уншигчдад төрүүлэхийг багагүй чармайх болжээ. Энэ бол Монгол оронд бодит социализм үнэхээр их амжилтанд хүрч БНМАУ-ын нэр хүнд дэлхий дахинд тууштай өсөн нэмэгдэж байгаа одоогийн нөхцөлд хөрөнгөтний суртал нэвтрүүлэг зөвхөн арга хэлбэрээ ямар нэг хэмжээгээр өөрчлөн зохицолдох гэж оролдож байгаагийн нэг илрэл мөн гэж үзэж болох байна.

Дэлхийн үндсэн хоёр системийн хооронд үзэл суртлын тэмцэл улам бүр хурцдаж байгаа одоогийн нөхцөлд хөрөнгөтний суртал нэвтрүүлэг өөрийн үзэл санаа, зорилгоо БНМАУ-ын хувьд ч өөрчлөхийг огт хүсэхгүй байгаа нь мэдээж хэрэг. Хөрөнгөтний хэвлэлд Монголын талаар нийтлэгдэж байгаа зүйлс зарим үед хоорондоо зөрчилдөн авцалдахгүй байх явдал ч үзэгдэж байгаа юм. Жишээ болгон бид Английн колони Гонконгт англи хэлээр нийтлэгддэг «Алс Дорнодын эдийн засгийн тойм» гэдэг долоо хоног тутмын сэтгүүлд БНМАУ-ын талаар сүүлийн үед нийтлэгдэж байгаа, өөрийн олж үзсэн зарим хэрэглэгдэхүүнийг авч үзье. Энэ сэтгүүлийн Монголыг харуулсан сурвалжлагчаар Алан Сандерс гэдэг Английн монголч-сэтгүүлч олон жилийн туршид ажиллаж байна.

1982 оны Улаанбаатарт болсон Олон улсын монголч эрдэмтний IV их хуралд оролцоходоо Алан Сандерс манай улсын аж ахуй, соёлын газруудаар явж, газар дээр нь шууд сурвалжлага хийж өөрийн сэтгүүлийн 1982 оны 11-р сарын дугаарт (118-р боть, № 47) Монголын тухай нэлээд хэмжээний хэрэглэгдэхүүнийг нийтлүүлжээ. Сэтгүүлийн нүүрэн талын хавтсыг Улаанбаатарын төв талбай дахь Сүхбаа-

*FAR EASTERN ECONOMIC REVIEW—Published weekly, every Friday, in Hongkong since 1946, by Far Eastern Economic Review Limited printed by South China Morning Post Ltd.

тарын хөшөөний өнгөт фото-зургаар (зохиогчийн өөрийнх нь авсан) чимэглэн, мөнхүү хавтсан дээр «Монгол хурдаараа давхиж байна» гэдэг гарчгийг том үсгээр бичжээ. Сэтгүүлийн уг дугаарт Монголын тухай А. Сандерсын сурвалжлага гол байр эзэлсэн нь тодорхой байна. Тэр сурвалжлагааны хэрэглэгдэхүүн бол (бүгд 6 хэсэг өгүүлэл) ер нь хөрөнгөтний сурвалжлагч А. Сандерс социалист Монголын одоогийн байдлын тухай ямаршуу гол санааг өвөрлөн хэрхэн яаж бичиж байдгийн нэг томруун жишээ мөн.

Монголын талаархи бүх хэрэглэгдэхүүн нь «Одоочлол бол цэцэглэлтийн уур амьсгал, илүү зөөлөн бодлогыг авчирч байна» гэсэн нийтлэг гарчигтай хэвлэгджээ. «Одоочлол (**modernisation**)» гэдэг нэр томъёогоор хөрөнгөтний зохиогчид аливаа орны орчин цагийн хөгжилтийг нэрлэдэг бөгөөд мөн энэ нэр томъёогоор ч манай улсын социалист бүтээн байгуулалтыг хэлж байгаа нь тодорхой.

Алан Сандерс Монголд хийсэн сурвалжлагааныхаа үндсэн дээр бичсэн зүйлстээ БНМАУ-ын гадаад дотоод бодлого, соёл боловсрол, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийг тухай бүрт нь хөндөн бичихийг оролджээ. Зохиогчийн нэр томъёогоор одоочлолын явцдаа Монгол багагүй амжилт олж байгаа тухай зарим тоо баримт, өөрийн нүдээр үзсэн зүйлсийг үндэслэн бичжээ. Жишээ нь одоогийн Монголын эдийн засаг нь зөвхөн ганц мал аж ахуйд түшиглэхээ больж мөн ихээхэн хэмжээний газар тариалан, уул уурхайн олборлолтын үйлдвэрт тулгуурлаж байна. Монгол малаа 25 сая-д хүргэх зорилтоо биелүүлэхэд тун ойртож байна. 1981 онд 9,4 сая төл авчээ. 1982 онд тус оронд үр тариа хураалт дээд хэмжээнд хүрч 505,500 тонн болов.

Сэтгүүлч өөрийн биеэр очиж сурвалжлага хийсэн Төв аймгийн Атарын сангийн аж ахуйн тухай тодорхой тоо баримт дурдан бичжээ. Уг аж ахуйгаар зохиогч тус улсын сангийн аж ахуйнуудыг төлөөлүүлэн харуулахыг оролдсон бололтой.

Төв аймгийн Атарын сангийн аж ахуй 1977 онд байгуулагдсан бөгөөд одоо 21000 га газар улаан буудай, ногоо зэргийг тарьж, 100 хавтгай дөрвөлжин километр нутагтаа 30 000 толгой мал өсгөж, 500 үнээ сааж, Улаанбаатарыг сүүгээр хангаж байдаг тухай бичжээ. Сангийн аж ахуй нь 120 трактор, үр тарианы 60 комбайн, 60 ачааны машинтай болно. Атарын сагийн аж ахуйд 3000 хүн аж төрж ажиллаж байдаг бөгөөд сургууль соёлын байгууллагатай болохыг дурджээ.

Тус улсын аж үйлдвэрийг Эрдэнэт хотын зэс, молибденийн баяжуулах комбинатаар төлөөлүүлэн бичихдээ уг хотод сэтгүүлч өөрөө биеэр очиж сурвалжилсан зүйлсээсээ тодорхой тоо баримт дурдан бичсэн байна. Зөвлөлт Холбоот Улсын тусламжтайгаар байгуулагдсан орчин цагийн энэ том үйлдвэрийг сурвалжлагч их шохоорхон сонирхож үзсэн нь илт байна.

А. Сандерс сэтгүүлч тус улсын Шинжлэх ухааны Академи, Улсын Их Сургууль, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн мөн Гандантэгчилэн хийдээр очиж улирдах хүмүүстэй нь уулзаж сурвалжлага хийсэн хэрэглэгдэхүүнээсээ мөн бичжээ.

«Алс Дорнодын эдийн засгийн тойм» сэтгүүлийн газраас гаргасан 1983 оны «Азийн жилийн лавлах» («**Asia 1983 Yearbook**») гэдэг номын Монголын тухай товч өгүүлэл, статистикийн мэдээг мөн А. Сандерс бичжээ. Азийн бүс нутгийн олон улсын нийгэм-эдийн засийн хөгжилтийг харьцуулан үзсэн уг лавлахын статистикийн хүснэгтээс үзэхэд БНМАУ нь хүн амын жил тутмын өсөлт, дундаж насны хэмжээ, 1000 хүнд оногдох больницын орны тоо, их эмчийн тоо, мөн оюутан сурагч-

дын тоо зэрэг үзүүлэлтээр Азийн бүс нутгийн орнуудын дотор дээгүүр байранд орж байгаа нь илэрхий байна.

Хэрэв Монголын талаар А. Сандерс сэтгүүлчийн нааштай бичсэн зүйлсийг бүдүүвчлэн голлож авч үзвээс уг сэтгүүлч бодит үнэн байдлыг уншигчдад мэдээлэхийг оролджээ гэмээр өрөөсгөл бөгөөд алдаатай сэтгэгдэл төрж болох юм. Үнэн хэрэг дээрээ А. Сандерсийн энэ арга хэлбэрийн цаана чухам ямар зорилго, санаа оршиж байгааг түүний бичсэн өгүүлүүдээс олж мэдэхэд төдий л төвөгтэй биш байна. Зохиогч зарим асуудлаар огт илэн далангүй гүтгэн муучлах арга ажиллагаанд автагдсан нь цөөнгүй байна. Сэтгүүлч үндсэндээ хоёр зүйлийг онцлон анхаарч мушгин гуйвуулж шүүмжлэхийг элдвээр чармайж байдаг нь тодорхой. Энэ нь нэгдүгээрт, Монгол—Зөвлөлтийн найрамдал, хамтын ажиллагаа: хоёрдугаарт, тус улсын нийгэм, улс төрийн байгуулал, манай нам төрийн удирдлага, түүний бодлогын асуудал юм. Сэтгүүлч БНМАУ-ын сүүлийн үеийн ололтыг өмнө бичсэнчилэн нэг талаар арга буюу хүлээн зөвшөөрөвч түүнийг тайлбарлахдаа тэрхүү амжилт бол Монголыг олон талаар «хүчтэй зөвлөлтчилж» байгаагийн үр дагавар мөн гэдэг ойлголтыг уншигчдад өгөхийг элдвээр оролдож байна.

БНМАУ-ын ерөнхий боловсролын сургуулийн сургалт хүмүүжлийн ажлыг цаашид сайжруулах тухай асуудлыг авч хэлэлцэж, тус улсын Ардын Боловсролын хуулийг баталсан БНМАУ-ын Ардын Их Хурлын чуулганы (1982 оны 12-р сарын) тухай сэтгүүлч мэдээлэхдээ тус чуулган зөвхөн ганц орос хэлэнд суралцах асуудлыг голчлон авч үзсэн мэтээр бичиж, монголчууд «орос хэлэнд довтлон орж байгаа» нь мөн л Зөвлөлтийн нөлөө хүчтэй болж байгаагийн баримт болгожээ. Зохиогчийн иймэрхүү маягаар бичсэн зүйлд хариу болгон өгүүлэхэд тус улсын хөгжилтийг эрчимжүүлэн түргэсгэх үйлсэд Зөвлөлт Холбоот Улсын ах дүүгийн сэтгэл харамгүй тусламж асар их ач холбогдолтойг хэн ч үгүйсгэж чадахгүй. Зөвлөлт Холбоот Улс анх байгуулагдсан цагаасаа эхлэн даруй 60 гаруй жил манай улсад бүх талын нөхөрсөг тусламж үзүүлсээр ирсэн билээ. Үүний дунд урьд Азийн ихээхэн хоцрогдсон орнуудын нэг байсан Монгол одоо орчин цагийн эрчимтэй хөгжиж байгаа социалист улс болов. Зөвлөлүүдийн орны хүн төрөлхтөнд нээж өгсөн нийгмийн дэвшлийн зам бол аливаа орныг «зөвлөлтчилөх» буюу «оросчлох» зам огтхон ч бус, харин энэ бол эрх чөлөө, тусгаар тогтнол, үндэсний сэргэн мандалтын зам, социалист хөгжлийн зам мөн гэдгийг зөвхөн ганц БНМАУ төдий бус мөн өөр бусад олон орны үлгэр жишээ яруу тод харуулна. Нийгмийн социалист хөгжлийн замыг дэлхийн үй олон улс түмнийг колончлон боолчилж, үндэсний төр улс, хэл соёл иргэншлийг нь үнэхээр бүрэлгэн сүйтгэж байсан капитализмтай адилтган хутгаж хэн ч чадахгүй.

Монголчууд орчин үеийн шинжлэх ухаан, техникийн нэг том хэл, өөрийн анд нөхдийн хэл Орос хэлийг суралцан эзэмшсэнээр үндэсний хэл бичиг, соёлоо орхиж байна гэж үү?!

Урьд Англи зэрэг империалист гүрнүүдийн колони хараат байсан орнуудад одоо ч гэсэн үй олон хүн бичиг үсэг мэдэхгүй байгаагийн дээр заримд нь англи, франц хэл албан хэл болж ноёрхоод эх хэл үндэсний бичиг, соёлын хөгжилтөд нь их саад бэрхшээл учруулсаар байгааг сэтгүүлч юу гэж үзэж байгаа бол гэмээр байна. Одоогийнх шиг үндэсний соёл иргэншил нь цэцэглэн хөгжиж, ард түмэн нь эрх чөлөөтэй, чинээлэг амьдарч байсан үе монголын ард түмний олон зуун жилийн түүхэнд хэзээ ч байгаагүй гэж монгол хүн хэн ч атугай зоригтой хэлж чадна. Энэ нь манай одоогийн хөгжил, аж амьдралд элдэв бэрхшээл

дутагдал байхгүй гэсэн үг огтхон ч бус бөгөөд бид түүнийгээ бодитойгоор шүүмжилж арилгахын төлөө тэмцэж байдаг билээ.

Эцэст нь тэмдэглэхэд А. Сандерс манай хэвлэлд шүүмжлэн нийтлэгдсэн дутагдал, бэрхшээлийг ихэд олзуурхан өлгөн авч манай хэвлэлийн мэдээгээр тус улсын одоогийн хөгжлийг элдвээр муучлан шүүмжлэх аргыг бас хэрэглэж байна. Тэгэхдээ уг асуудлыг хэтрүүлэн дэвэргэж, өөрийнхөөрөө гуйвуулан тайлбарлах явдал зохиогчийн гол зорилго болж байдгийг олж мэдэхэд төдий л төвөггүй байна.